

1. Орчин үеийн нийгэм дэх эдийн засгийн баялаг, орлогын хэмжээ, ажил мэргэжлээр ялгагдах дээд, дунд, доод ангиас тогтдог, хувийн байр сууриа өөрчлөх боломжтой нээлттэй давхраажилтын хэв маяг аль нь вэ?

- а. язгуур б. анги в. каст г. Боолчлол

2. Удирдлага, менежер, мэргэжилтэн, туслах, гүйцэтгэх, техникийн түвшний оюуны хөдөлмөр эрхлэгчдийг юу гэж нэрлэдэг вэ?

- а. ажилчин анги б. цагаан захтан в. хөх захтан г. Сэхээтэн

3. Дундад зууны үед оршин байсан давхраажилтын хэв маяг аль нь вэ?

- а. язгуур б. анги в. каст г. боолчлол

4. Аж үйлдвэржилтийн нийгмийн өмнөх үеийн нийгмээс ялгарах ялгааг тодруулж, гемайншафт\ хөдөөний буюу уламжлал\ , гезеллшафт\ хотын буюу орчин үеийн\ гэсэн ойлголт ашиглан хэн тайлбарласан бэ?

- а. К.Маркс б. Г.Ленский ,Ж.Ленский в.Ф.Тённис г. Гилберт

5.Хувь хүний эдийн засгийн байр суурийг ямар үзүүлэлтээр хэмжих вэ?

- а. боловсрол б. орлого в. ажил мэргэжил г. эрх мэдэл

6. Орлого олж амьжиргаагаа залгуулахаар эрхэлж буй үйл хэрэг

- а. ажил мэргэжил б. орлого в. боловсрол г. албан тушаал

7. Социализмын үеийн Монголын нийгмийн давхраажилтыг судалж 4 ангийн бүтэцтэй байсныг тодорхойлсон судлаач аль нь вэ?

- а. О. Мөнхбат б. Ц.Уртнасан в. Х. Гүндсамбуу г. Б. Энхцэцэг

8. XII-XIV зуунд дээд давхраанд Чингис хааны алтан ураг, талын язгууртнууд, мянгатын ноёд, тэргүүн бөө нар багтаж байв . Жирийн иргэд нь “ улсын иргэн”, “ харьяат иргэн” гэж хуваагджээ. Харин Манжийн эрхшээлийн үед дээд давхраанд

хошууны ноёд, тайж лам нар байв. Эдгээр түүхэн үеүдэд нийгмийн давхраажилтын ямар хэв маяг байсан бэ?

а. язгуур б. анги в. каст г. Боолчлол

9.Тэгш бус байдал үүсэх нөхцлийг зөв дараалуулсныг олж дугуйлна уу.

10. Дараах өгөгдлийг зөв тохируулна уу.

А	Дээдийн доод анги	1	Тун бага хувийг эзэлдэг ч баялгийн дийлэнхийг эзэмшдэг
Б	Дундын дээд анги	2	Маш бага орлогтой, мэргэжилгүй, энгийн ажил эрхэлдэг
В	Ядуу ажилчин анги	3	Тун цөөн хувийг эзэлдэг. Байр суурь нь харьцангуй нээлттэй байдаг.
Г	Доод анги	4	Тогтмол орлогын эх үүсвэргүй, бага боловсролтойэсвэл боловсролгүй, нийгмийн халамжаас хамааралтай амьдардаг
Д	Дээдийн дээд анги	5	Мэргэжилтэн, жижиг бизнес эрхлэгч, инженер зэрэг цагаан захтан, мэргэжсэн хөх захтан